

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаадын иргэн, харьяатын Хойд бүс дэх газрын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/25/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
2024 он	Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:Baasansurens@audit.gov.mn">Baasansurens@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СЭА-2024/25/НА-СТА-ТШЗ

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11-12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12-13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13-15
4. Аудитын тайлан	15-17
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15-16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16-17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19-20

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГИХГ	Гадаадын Иргэн, Харьяатын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХЗДХС	Хууль зүй Дотоод Хэргийн Сайд
ХЗДХЯ	Хууль зүй Дотоод Хэргийн Яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## **Аудитын гол асуудал**

Тус газар 2020-2022 онд түрээсийн нөхцөлөөр нийт 24,000.0 мянган төгрөгийн үнэтэй 2 автомашины дулаан зогсоолыг худалдан авах гэрээ байгуулан төлбөрийг барагдуулж, үндсэн хөрөнгөд бүртгэсэн боловч уг зогсоолууд нь байгууллагын эзэмшилд бус иргэн Г.Батбаярын нэр дээр бүртгэлтэй байна.

Энэ нь хөрөнгө үрэгдэх эрсдэлийг үүсгэж байгаа тул 2 автомашины зогсоолыг хувь хүний эзэмшлээс хасуулж, байгууллагын эзэмшилд бүртгүүлэх нь зүйтэй юм.

## **Бусад асуудлын хэсэг**

Тус газар нь тайлант оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд 3 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 76.6 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>102,102,317.40</b>	<b>117,339,302.10</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>102,102,317.40</b>	<b>117,339,302.10</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>5,305,211.00</b>	<b>3,982,519.00</b>
35130	Эм боох материал	5,305,211.00	3,982,519.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>96,797,106.40</b>	<b>113,356,783.10</b>
35410	Бичиг хэргийн материал	992,125.00	2,443,425.00
35420	Аж ахуйн материал	1,794,850.00	6,074,450.00
35430	Сэлбэг хэрэгсэл	18,201,000.00	19,806,500.00
35440	Түлш, шатах тослох материал	549,000.00	2,982,500.00
35450	Барилгын засварын материал	225,000.00	5,064,500.00
35470	Бусад хангамжийн материал	75,035,131.40	76,985,408.10
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>505,049,948.78</b>	<b>458,874,839.89</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>505,049,948.78</b>	<b>458,874,839.89</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>259,892,948.78</b>	<b>214,171,589.89</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	63,264,054.11	63,264,054.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	(22,587,640.43)	(25,135,493.98)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	245,500,000.00	245,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(80,652,777.72)	(115,673,611.20)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	101,272,139.46	85,557,496.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(68,831,985.12)	(59,189,339.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,514,219.99	30,455,219.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,585,061.51)	(10,606,735.54)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>245,157,000.00</b>	<b>244,703,250.00</b>
39301	Программ хангамж	1,980,000.00	1,980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,485,000.00)	(1,938,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	244,662,000.00	244,662,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>607,152,266.18</b>	<b>576,214,141.99</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>607,152,266.18</b>	<b>576,214,141.99</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>607,152,266.18</b>	<b>576,214,141.99</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	244,662,000.00	244,662,000.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	244,662,000.00	244,662,000.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>357,706,127.54</b>	<b>326,768,003.35</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	332,319,866.16	357,706,127.54
51220	Тайлант үеийн үр дүн	25,386,261.38	(30,938,124.19)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,784,138.64	4,784,138.64
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>607,152,266.18</b>	<b>576,214,141.99</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>706,180,578.00</b>	<b>995,647,140.20</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>49,617,378.00</b>	<b>21,900,540.20</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>49,617,378.00</b>	<b>21,900,540.20</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>14,000,000.00</b>	<b>-</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,000,000.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	35,617,378.00	21,900,540.20
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>656,563,200.00</b>	<b>973,746,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>607,128,200.00</b>	<b>973,746,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	607,128,200.00	973,746,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>49,435,000.00</b>	<b>-</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,435,000.00	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>679,924,186.62</b>	<b>1,017,122,500.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>679,924,186.62</b>	<b>1,017,122,500.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>659,968,620.71</b>	<b>770,482,399.91</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>449,773,311.42</b>	<b>591,989,898.77</b>
210101	Үндсэн цалин	270,857,543.16	341,415,952.81
210102	Нэмэгдэл	87,889,053.52	125,889,945.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	71,232,562.08	94,919,684.84
210104	Урамшуулал	19,794,152.66	29,764,315.77
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>56,609,932.67</b>	<b>75,376,014.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,373,136.67	46,865,814.99
210202	Тэтгэмжийн даатгал	5,058,899.00	7,126,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,547,999.00	5,702,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,311,999.00	1,425,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,317,899.00	14,255,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>31,607,600.00</b>	<b>11,640,827.26</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,999,100.00	454,866.00
210302	Түлш, халаалт	4,305,300.00	1,656,272.37
210303	Цэвэр, бохир ус	1,085,300.00	746,008.89
210304	Байрны түрээс	24,217,900.00	8,783,680.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>43,968,205.64</b>	<b>17,807,200.00</b>
210401	Бичиг хэрэг	2,794,240.00	2,837,650.00
210402	Тээвэр, шатахуун	18,126,300.00	11,729,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,989,184.00	2,237,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,279,170.00	1,002,550.00
210408	Бараа материал акталсны зардал	15,779,311.64	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,711,540.00</b>	<b>1,377,692.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,677,840.00	1,322,692.00
210604	Урсгал засвар	3,033,700.00	55,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>1,476,800.00</b>	<b>1,594,000.00</b>

210702	Дотоод албан томилолт	1,476,800.00	1,594,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,949,516.00</b>	<b>9,037,618.00</b>
210803	Даатгалын үйлчилгээ	348,975.00	348,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	249,821.00	211,243.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	178,000.00	1,500,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,084,720.00	6,889,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>66,871,714.98</b>	<b>61,659,148.89</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,366,800.00	2,243,240.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,904,600.00	1,760,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,600,314.98	57,655,108.89
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,955,565.91</b>	<b>246,640,100.98</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,244,000.00</b>	<b>117,978,571.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,244,000.00	2,300,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	115,678,571.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>18,711,565.91</b>	<b>128,661,529.98</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,711,565.91	128,661,529.98
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>26,256,391.38</b>	<b>(21,475,360.69)</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>870,130.00</b>	<b>9,462,763.50</b>
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	870,130.00	9,462,763.50
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>25,386,261.38</b>	<b>(30,938,124.19)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>656,563,200.00</b>	<b>973,746,600.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>656,563,200.00</b>	<b>973,746,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>607,128,200.00</b>	<b>973,746,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	607,128,200.00	973,746,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>49,435,000.00</b>	<b>-</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,435,000.00	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>622,173,200.00</b>	<b>970,776,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>622,173,200.00</b>	<b>970,776,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>602,217,634.09</b>	<b>724,136,499.02</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>449,773,311.42</b>	<b>591,989,898.77</b>
210101	Үндсэн цалин	270,857,543.16	341,415,952.81
210102	Нэмэгдэл	87,889,053.52	125,889,945.35

210103	Унаа хоолны хөнгөлөлт	71,232,562.08	94,919,684.84
210104	Урамшуулал	19,794,152.66	29,764,315.77
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>56,609,932.67</b>	<b>75,376,014.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,373,136.67	46,865,814.99
210202	Тэтгэмжийн даатгал	5,058,899.00	7,126,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,547,999.00	5,702,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,311,999.00	1,425,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,317,899.00	14,255,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,207,600.00</b>	<b>14,640,827.26</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,999,100.00	454,866.00
210302	Түлш, халаалт	4,905,300.00	4,656,272.37
210303	Цэвэр, бохир ус	1,085,300.00	746,008.89
210304	Байрны түрээс	24,217,900.00	8,783,680.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,398,444.00</b>	<b>22,827,300.00</b>
210401	Бичиг хэрэг	1,864,500.00	3,104,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,815,700.00	14,056,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,989,184.00	2,237,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,729,060.00	3,429,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>25,048,700.00</b>	<b>6,500,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,496,700.00	-
210604	Урсгал засвар	22,552,000.00	6,500,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>1,476,800.00</b>	<b>1,594,000.00</b>
210702	Дотоод албан томиллолт	1,476,800.00	1,594,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,242,546.00</b>	<b>6,148,218.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	348,975.00	348,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	249,821.00	211,243.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,460,750.00	5,500,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	75,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,460,300.00</b>	<b>5,060,240.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,876,200.00	2,668,240.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,584,100.00	2,392,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,955,565.91</b>	<b>246,640,100.98</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,244,000.00</b>	<b>117,978,571.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,244,000.00	2,300,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	115,678,571.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>18,711,565.91</b>	<b>128,661,529.98</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,711,565.91	128,661,529.98
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>34,390,000.00</b>	<b>2,970,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>34,390,000.00</b>	<b>2,970,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>34,390,000.00</b>	<b>2,970,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>34,390,000.00</b>	<b>2,970,000.00</b>

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,390,000.00	2,970,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(34,390,000.00)</b>	<b>(2,970,000.00)</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	332,319,866.16	581,766,004.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	332,319,866.16	581,766,004.80
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	25,386,261.38	25,386,261.38
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	357,706,127.54	607,152,266.18
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	357,706,127.54	607,152,266.18
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	357,706,127.54	607,152,266.18
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(30,938,124.19)	(30,938,124.19)
20	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	326,768,003.35	576,214,141.99

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	973,746,600.00	845,085,070.02	128,661,529.98	86.79
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	973,746,600.00	845,085,070.02	128,661,529.98	86.79
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	855,767,900.00	727,106,499.02	128,661,400.98	84.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,518,900.00	59,740,585.26	778,314.74	98.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	706,154,600.00	591,989,898.77	114,164,701.23	83.83
210101	Үндсэн цалин	355,737,300.00	341,415,952.81	14,321,347.19	95.97
210102	Нэмэгдэл цалин	201,457,400.00	125,889,945.35	75,567,454.65	62.49
210103	Унаа хоолны нэмэгдэл	107,480,700.00	94,919,684.84	12,561,015.16	88.31
210104	Урамшуулал	41,479,200.00	29,764,315.77	11,714,884.23	71.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,094,400.00	75,376,014.99	13,718,385.01	84.6
210201	Тэтгэврийн даатгал	60,584,200.00	46,865,814.99	13,718,385.01	77.36
210202	Тэтгэмжийн даатгал	7,126,900.00	7,126,900.00	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,702,200.00	5,702,200.00	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	1,425,700.00	1,425,700.00	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	14,255,400.00	14,255,400.00	-	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,232,400.00	14,640,827.26	591,572.74	96.12
210301	Гэрэл, цахилгаан	539,100.00	454,866.00	84,234.00	84.38
210302	Түлш, халаалт	4,691,000.00	4,656,272.37	34,727.63	99.26
210303	Цэвэр, бохир ус	1,104,300.00	746,008.89	358,291.11	67.55
210304	Байрны түрээс	8,898,000.00	8,783,680.00	114,320.00	98.72
2104	Хангамж, бараа материалын зардал	22,827,300.00	22,827,300.00	-	100
210401	Бичиг хэрэг	3,104,000.00	3,104,000.00	-	100
210402	Тээвэр, шатахуун	14,056,500.00	14,056,500.00	-	100
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,237,500.00	2,237,500.00	-	100
210406	БҮТЭЭҮйлс	3,429,300.00	3,429,300.00	-	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,500,000.00	9,470,000.00	30,000.00	99.68
210601	Багаж, техник хэрэгсэл	3,000,000.00	2,970,000.00	30,000.00	99
210604	Урсгал засвар	6,500,000.00	6,500,000.00	-	100
2107	Томилолт, зочны зардал	1,600,000.00	1,594,000.00	6,000.00	99.63
210702	Дотоод албан томилолт	1,600,000.00	1,594,000.00	6,000.00	99.63
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,262,500.00	6,148,218.00	114,282.00	98.18
210803	Даатгалын үйлчилгээ	349,000.00	348,975.00	25.00	99.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	249,900.00	211,243.00	38,657.00	84.53
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,500,000.00	5,500,000.00	-	100
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	75,600.00	-	75,600.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,096,700.00	5,060,240.00	36,460.00	99.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,704,700.00	2,668,240.00	36,460.00	98.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,392,000.00	2,392,000.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,978,700.00	117,978,571.00	129.00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,978,700.00	117,978,571.00	129.00	100
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,300,000.00	2,300,000.00	-	100

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	115,678,700.00	115,678,571.00	129.00	100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	855,767,900.00	845,085,070.02	10,682,829.98	98.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	855,767,900.00	845,085,070.02	10,682,829.98	98.75
131001	Улсын төсвөөс санхүүжих	855,767,900.00	845,085,070.02	10,682,829.98	98.75

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газар / Цаашид ГИХГ-ын Хойд бүс дэх газар гэх/ нь “Хүний эрх, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт хүрсэн нээлттэй, хариуцлагатай төрийн үйлчилгээг явуулах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэдэд тавих хяналтыг хэрэгжүүлэх,
- Иргэний харьяалал, цагаачлалын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд ГИХГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсээс хяналт тавьж ажилладаг бөгөөд 2023 оны 04 дүгээр сард захиргааны болон санхүүгийн 2022 он, 2023 оны нэгдүгээр улирлын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, санхүүгийн үйл ажиллагаанд 18 чиглэлээр албан даалгавар өгч, хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгосон байна.

Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдөр албан даалгаврын биелэлтийг гаргаж тайлагнасан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ГИХГ-ын Хойд бүс дэх газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ХЗДХС-ын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/87 дугаар тушаалаар ХЗДХЯ болон түүний харьяа байгууллагын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

ГИХГ-ын Хойд бүс дэх газар нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 30,938.1 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	102,102.3	117,339.3	15,237.0
Үндсэн хөрөнгө	505,049.9	458,874.8	(46,175.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>607,152.2</b>	<b>576,214.1</b>	<b>(30,938.1)</b>
Засгийн газрын хувь оролцоо	607,152.2	576,214.1	(30,938.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн</b>	<b>607,152.2</b>	<b>576,214.1</b>	<b>(30,938.1)</b>

Дээрх хүснэгтээс үзэхэд нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данс байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 117,339.3 мянган төгрөг болж өмнөх оноос 15,237.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 35,212.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, ГИХГ-аас 16,852.5 мянган төгрөг /12,307.4 мянган төгрөгийн нормын хувцас, 3,515.0 мянган төгрөгийн шатахуун, 1,030.1 мянган төгрөгийн улсын мэдээллийн маягт/ -ийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан болон 27,328.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, систем хооронд 9,498.9 мянган төгрөгийн бараа материал /1,200.7 мянган төгрөгийн нормын хувцас, 8,262.0 мянган төгрөгийн улсын мэдээллийн маягт, 36.2 мянган төгрөгийн бусад хангамжийн материал/-ыг шилжүүлснээс,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 458,874.8 мянган төгрөг болж 46,175.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 2,970.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсан, ТӨБЗГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 16 дугаар албан бичгийн дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаснаар 8,510.0 мянган төгрөгийн хөрөнгө /6,327.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2,183.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил/ -ийг дахин үнэлж орлогод авсан, 57,655.1 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулснаас,
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 576,214.1 мянган төгрөг болж 30,938.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

ГИХГ-ын Хойд бүс дэх газар нь 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 729,844.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар бууруулж баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 52,045.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 4,368.8 мянган төгрөг,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 16,959.0 мянган төгрөг,
- Хангамж, бараа материалын зардлыг 51,677.4 мянган төгрөг,
- Нормативт зардлыг 5,750.0 мянган төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 23,180.0 мянган төгрөг,
- Томилолт, зочны зардлыг 7,740.0 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 5,449.0 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 10,503.3 мянган төгрөг,
- Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлыг 6,900.0 мянган төгрөг зэрэг нийт 132,527.5 мянган төгрөгөөр бууруулж 649,361.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 324,385.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн төсвийн тодотгол, зохицуулалт хийж /Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 175,361.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 22,745.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 11,300.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 2,000.0 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 1,000.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 4,000.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,600.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 116,878.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, байр ашиглахтай холбоотой зардлыг 10,500.0 мянган төгрөгөөр бууруулсан байна./ 973,746.6 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 973,746.6 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр бүрэн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 845,085.1 мянган төгрөг буюу 86.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 128,661.5 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	855,767.9	727,106.5	(128,661.4)	84.9
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	117,978.7	117,978.6	(0.1)	99.9
	<b>Дүн</b>	<b>973,746.6</b>	<b>845,085.1</b>	<b>(128,661.5)</b>	<b>86.8</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130012408 дугаар дансанд тайлант онд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ГИХГ-ын Хойд бүс дэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ГИХГ-ын Хойд бүс дэх газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 679,924.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,799.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд тус газрын батлагдсан төсөвт материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,017,122.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон 10,171.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

1.Урсгал засварын зардлын хэмнэлт болох 4,839.5 мянган төгрөгөөр барилгын материал худалдан авч нөөцөлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн

15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага ...-д дараах зүйлийг хориглоно:” 15.1.6 дахь “Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.Хууль тогтоомж сурталчлах шторк хийлгэхээр Мюзик хаус ХХК-тай гэрээ байгуулан бараа, үйлчилгээний бусад зардлаас 1,850.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага ... -д дараах зүйлийг хориглоно:” 15.1.4 дэх “ ... байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ГИХГ-ын Хойд бүс дэх газар нь шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих 28 төрлийн 154 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

###### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

###### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 600.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 14,728.9 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгснийг нотлох баримттай тулган баталгаажуулахад бүрэн биелсэн байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	600.0	1	600.0	100.0
Зөвлөмж	1	14,728.9	1	14,728.9	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>15,328.9</b>	<b>2</b>	<b>15,328.9</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн гэрэл цахилгааны зардлыг 350.0 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 850.0 мянган төгрөгөөр дутуу, байрны түрээсийн зардлыг 1,200.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан алдааг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 6,689.5 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 6,689.5 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3 зөрчилд зөвлөмж өгөв.

##### 5.1 Албан шаардлага

1. Жилийн эцэст урсгал засварын зардлын хэмнэлт 4,839.5 мянган төгрөгөөр чухал шаардлагагүй барилгын материал бэлтгэж, нөөцлөн, үлдэгдлээр тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь “...Төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд .... төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага ...-д дараах зүйлийг хориглоно.” 15.1.6 дахь “.... шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг жилийн эцэст төсөвт татан төвлөрүүлэх, төсвийн жилд зарцуулагдахгүй бараа материал нөөцлөхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Бараа, үйлчилгээний бусад зардлаас хууль тогтоомж сурталчлах сурталчилгааны материал хийлгэхээр Мюзик хаус ХХК-д 1,850.0 мянган төгрөгийг шилжүүлж, материалыг хүлээн аваагүй атал урьдчилж гарсан зардлаар бүртгэж, тайлагнаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага ... -д дараах зүйлийг хориглоно.” 15.1.4 дэх “ ... байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат

болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, 14.4.2 дахь “... **авлага**”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.28 дахь “Бэлтгэн нийлүүлэгч болон хувь хүмүүст төлсөн урьдчилгаа, ба урьдчилан гарсан зардлыг: Дт.Урьдчилж төлсөн төлбөрүүд, Кт.Мөнгөн хөрөнгө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй байх, үүссэн авлагыг бүртгэл, тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Үнэт цаасны жилийн эцсийн тооллоготой холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Жилийн эцэст албан хаагчдын гар дээр байгаа үнэт цаас буюу “Шийтгэлийн хуудас”-ны тооцоог хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:” 12.2.1 дэх “*жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө*”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь “*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:*”, 20.2.6 дахь “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан гаргахын өмнө албан хаагчдын гар дээр байгаа шийтгэлийн хуудасны тооллого тооцоог хийж, үр дүнг тооцож байх.

### **2. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт: Агуулахаас тавьж олгож, авто машинд суурилуулсан мотор, дугуй зэрэг бараа материалыг зардлаар бус үлдэгдлээр бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС-12 “Бараа материал”-ийн 9 дэх “*Бараа материал гэдэг нь дараах хөрөнгүүд юм:*” 9 (б)-д “*Үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах, түгээн хуваарилагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа*”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.21-ын (г)-д “*Бараа материалыг ажил үйлчилгээнд ашиглахаар тавьж олгоход: Дт. Зардал /Зардлын зүйлээр/, Кт. Хангамжийн материалын холбогдох дэд данс*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Бараа материалын бүртгэлийг холбогдох стандарт, зааврын дагуу үнэн зөв хийж, 2024 оны эхний хагас жилийн тайланд залруулах.

### 3. Хөрөнгийн бүртгэл, үнэлгээтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй, элэгдлээрээ зардлаа нөхсөн, үлдэх өртөггүй боловч эд ангиудыг засварлаж, зардал гаргаж буй NISSAN PATROL маркын авто машиныг бодит үнэ цэнээр нь үнэлүүлэх саналыг холбогдох байгууллагуудад уламжилж, шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн..... эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна .

3.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

**Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>1</sup>-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тогтмол зардлыг санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд зөрүүтэй тайлагнасан	1	1,200.0			1	1,200.0	1	1,200.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,200.0</b>			<b>1</b>	<b>1,200.0</b>	<b>1</b>	<b>1,200.0</b>				

<sup>1</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлээгүй.	1	4,839.5			1	4,839.5						
Урьдчилж гарсан зардлыг бүртгэж, тайлагнаагүй	1	1,850.0			1	1,850.0						
"Шийтгэлийн хуудас"-ны тооцоог хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.	1	-					1	-				
Бараа материалыг буруу бүртгэж, тайлагнасан	1	-					1	-				
Хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлээгүй	1						1					
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>6,689.5</b>			<b>2</b>	<b>6,689.5</b>	<b>3</b>	<b>-</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								